

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ  
БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2011.03.09

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, үр дүн	Үнэлгээ	
			Хувь	Оноо
1	Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана	Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг удирдлага болгон аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийг батлуулан ажиллаж ирлээ. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний аймаг, орон нутагт хамааралтай 95 зорилт, 174 арга хэмжээний хэрэгжилтийн явцын үнэлгээ 57,2 хувь, тухайн жилийн буюу 2010 оны хэрэгжилтийн үнэлгээ 95.3 хувьтай байна.	95.3	4.8
2	Төр, засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана	Аймгийн Засаг дарга нь Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон аймгийн ИТХурлын тогтоол, шийдвэрийг үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэгжүүлж 2010 онд 122 тогтоол, шийдвэрийн 236 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллаа. Аймгийн ЗДТГ, ИТХ-аас 06 дугаар сард сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, төрийн захиргааны түшмэлүүдэд нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангах чиглэлээр ХЗДХЯамнаас сургагч багш урьж сургалт явуулан, аймгийн Засаг даргын шийдвэр гаргах журмыг шинэчлэн баталлаа. 2010 онд гаргасан 419 захирамж нь Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль, тогтоомжид бүрэн нийцсэн эрхийн актууд болж, аймаг Засаг даргын нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан 1 захирамжийг хянуулан улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв. Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг даргын захирамж, төсвийн ерөнхий менежерүүдийн 2009-2010 оны тушаал шийдвэрүүдэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 91 эрх зүйн актад өөрчлөлт хөдөлгөөн оруулан, 17 эрх зүйн актыг хүчингүй болгуулахаар шийдвэрлэж, захирамжлалын баримт бичиг нь хууль, эрх зүйн үндэслэлгүй, хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэсэн, эрх зүйн үндэслэл буруу авагдсан зэрэг зөрчилтэй захирамж боловсруулан баталгаажуулсан Бүрд, Богд, Сант сумдын Засаг дарга нарт сануулах шийтгэл ногдуулж, тушаал шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлд хяналт-шинжилгээ хийлгээгүй Бүрд, Баян-Өндөр, Бат-Өлзий, Тарагт, Уянга сумдын эмнэлэг, Төгрөг сумын ЕБС, Есөнзүйл сумын цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт болон хяналт- шинжилгээний явцад тушаал шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэл, баримт бичгийн боловсруулалт, албан хэргийн стандарт хангалтгүй	100	5.0

		байгаа Бүрд, Есөнзүйл, Баруунбаян-Улаан, Тарагт, Уянга, Хайрхандулаан сумдын ерөнхий боловсролын дунд сургууль, Гучин-Ус, Өлзийт, Богд, Нарийнтээл, Сант, Төгрөг сумдын цэцэрлэг, Хужирт, Тарагт, Сант, Зүүнбаян-Улаан, Богд, Нарийнтээл, Есөнзүйл, Баян-Өндөр, Баянгол, Гучин-Ус сумдын Соёлын төв, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Богд, Сант сумдын эмнэлгийн ерөнхий менежерүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгав.		
3	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ	<p>“Нэг цонхны үйлчилгээний төв”-ийг 2010 онд Арвайхээр суманд байгуулан ажиллуулж, Швейцарын хөгжлийн агентлагын төслийн санхүүжилт 30,2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 8,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар компьютер, тавилга, техник хэрэгслийг суурилуулж, үйл ажиллагаа нь төлөвшин тогтмолжиж, төрөөс иргэдэд үзүүлдэг анхан шатны үйлчилгээг 103385 иргэнд нэг цэгээс үзүүлж, үйлчилгээний хүртээмж, үйлчлүүлэгчдийнхээ тоогоор Хөвсгөл, Дархан-Уул аймгийн дараа орж байна.</p> <p>Засгийн газрын “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, төрийн байгууллагуудын ажлыг үнэлж, дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгон жил бүр дүгнэж хэвшлээ.</p> <p>Аймгийн албан ёсны цахим хуудас /web site/-ыг <a href="http://www.uvurkhangai.mn">www.uvurkhangai.mn</a> /www.uvurkhangai.gov.mn/ шинээр ашиглалтад оруулж иргэд төрийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүртэх боломжтой боллоо. Уг цахим хуудасны давуу тал нь төрийн зарим үйлчилгээ /архивын лавлагаа, өргөдөл хүсэлт, үйлчилгээний нөхцөл, үнэ тариф/-г хүргэх, орон нутгийн удирдлагын шийдвэрийг хайлтын системээр хайж эх хувиар татаж авах, цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол хүлээн авах орчин үеийн веб программаар бичсэн сайт боллоо. Сард дундажаар 250-300 хүн мэдээлэл авч байна.</p> <p>2010 онд Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Уянга, Богд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдад хуулийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, иргэдэд хуулийн байгууллагуудын үйлчилгээг газар дээр түргэн шуурхай үзүүлж, хууль зүйн сургалт зохион байгуулах зэрэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэн, аймгийн хууль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлж, хуулийн байгууллагуудын Вэб сайтыг нээн ажиллуулав.</p> <p>“Орон нутгийн санаачлага” ТББ-аас хэрэгжүүлж буй “Төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авалтын ил тод байдлыг хангах нь” төслийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн салбарын зөөлөн эдлэл, нормын хувцасны нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтын үзэсгэлэнг зохион байгуулж, тайланг хэлэлцүүлэн ажиллаж ирлээ.</p>	100	5.0
4	Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг	2010 онд 4.3 тэрбум төгрөг болж урьд оноос 1.7 дахин өссний дотор оёдлын	100	5.0

	<p>сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авлига, хээл хахуулийг цээрлэн ажиллана</p>	<p>үйлдвэрлэл 209.0 хувь мод, модон эдлэл, тавилга 182.7 хувь, боловсруулах аж үйлдвэр 182.6 хувь, уул уурхай, олборлох аж үйлдвэр 179.4 хувь өссөн байна.</p> <p>Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 106.2 хувьтай, орон нутгийн төсвийн урсгал зардлын 71.5 хувийг орон нутгийн орлогоор бүрдүүллээ.</p> <p>Авилгатай тэмцэх газарт аймгийн төрийн албан хаагч нийт 495 хүний хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй тайлан, шинээр ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдын мэдээллийг хүргүүллээ. Нийт төрийн албан хаагчид нь авилга хээл хахуулийн хэрэгт холбогдсон зөрчил дутагдалгүй ажиллав.</p> <p>Онлайн сүлжээнд холбосноор тухайн байгууллагын батлагдсан төсвийг зардал нэг бүрээр программд оруулдаг тул зардал хооронд гүйлгэх, данс улайсгах, батлагдсан төсвөө хэтрүүлэн зарцуулах зөрчлүүд буурч, төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой заавар журмын хэрэгжилт сайжирч, байгууллагын санхүүжилтийг цаг хугацаанд нь олгон, аймгаас сумдад тавих хяналт сайжирч, мэдээ тайланг богино хугацаанд үнэн зөв гарган нэгтгүүлэх болов. Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан зорилт арга хэмжээ тус бүрийн өртөгийг тооцож гэрээнд тусгаж ажиллав.</p> <p>Төсвийн зарлагын норматив боловсруулан журамлах, орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн хуваарилалтыг хийснээр төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийг ижил тэгш зарчмаар хуваарилан үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах чухал алхам болж байна. Аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг “Таны элч”, “Гурвалжин мэдээ” сонин, иргэдэд мэдээллээр үйлчлэх төвөөр иргэдэд ил тод нээлттэй тогтмол мэдээлж ирлээ.</p> <p>“Төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах тухай” аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын биелэлтийг Зүүнбаян-Улаан, Хужирт, Богд, Гучин-Ус, Төгрөг, Сант, Баян-Өндөр, Хархорин, Бат-Өлзий сумдад шалган үнэлэлт дүгнэлт өгөв.</p>		
5	<p>Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ, соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана</p>	<p>2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын стандартын биелэлт 98 хувь, суурь боловсролын стандартын хэрэгжилт 98 хувь, бүрэн дунд боловсролын стандартын хэрэгжилт 99.7 хувь, аймгийн дүнгээр боловсролын стандартын биелэлт 98.5 хувьтай үнэлэгдлээ.</p> <p>2010 оны элсэлтийн ерөнхий шалгалтанд нийт 1538 суралцагч давхардсан тоогоор 6204 хичээлээр хамрагдаж, нийт шалгуулагчдын дундаж оноо 505.5 байгаа нь улсын дунджаас /496.8/ 8.6 оноогоор дээгүүр байна. Мөн гадаад хэлээс бусад 8 хичээлийн дундаж улсын дунджаас 7.2-16.6 оноогоор дээгүүр байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 19 сумын 58 багт нүүдлийн гэр цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж, 2-5 насны 3517 хүүхэд хамрагдсанаар СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин 73.7 хувь, бохир жин 82.8 хувьд хүрч, 2009 онтой</p>	95	4.7

		<p>харьцуулахад 8.7 хувиар өссөн байна.</p> <p>Сум бүрийг “Орон нутаг судлах танхим”-тай болгох зорилт тавьж сумдын 83.3 хувь нь танхимтай боллоо. Соёлын төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тогтмолжуулах зорилгоор “Миний нутаг сайхан” спорт, урлагийн наадам, аймгийн “Хүүхдийн урлагийн их наадам”, хөгжим, бүжгийн сургалтуудыг зохион байгуулсны үр дүнд сумдын Соёлын төвийн дэргэдэх хүүхэд, залуучуудын авъяасыг нээн, хөгжүүлэх дугуйлангуудын үйл ажиллагаа жигдэрлээ. Соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд зорилуж 29.0 сая төгрөг, барилгын засвар тохижилтод улсын болон орон нутгийн төсвөөс 438.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.</p> <p>ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, БСШУЯ-ны “Соёлын өвийн төв”-тэй хамтран соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хадгалалт хамгаалалтад нь хяналт тавих, эрэн сурвалжлах, шинээр олж илрүүлэх ажлыг зохион байгуулан 10 сумын 240 гаруй дурсгал, 2050 хиргисүүрүүдийн байршлыг тогтоон координатыг тогтоож, улсын 9, аймгийн 26, сумын хамгаалалтын зэрэглэлтэй 210 дурсгал, 2050 хиргисүүрийн жагсаалтыг гарган аймгийн бүртгэл мэдээллийн санг баяжууллаа.</p> <p>“Эрүүл мэндийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө 2010-2015”-г боловсруулан батлав. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангамж 2.2 хувиар нэмэгдэж, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч, төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн эмнэлгүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын анхдугаар зөвлөгөөнийг улсын хэмжээнд анх удаа орон нутагт зохион байгууллаа.</p> <p>“VSO” ОУБ-тай хамтран “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх” нь төслийг 3 суманд амжилттай хэрэгжүүлэв</p> <p>2010 онд эхийн эндэгдэл гаргаагүй, БЗДХ 19.5 промиллиэр буурсан амжилттайгаар салбарын хөгжлийг жигд хангах дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүллээ.</p> <p>2010 онд ажилгүйдлийн түвшин 4.5 хувьд хүрч урьд оны мөн үеэс 0.4 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд байнгын 1726, түр 811 нийт 2537 ажлын байр бий болгож <a href="http://www.ejob.mn">www.ejob.mn</a> вэб сайтанд бүртгэлээ. Нийтийг хамарсан ажлаар 1478 түр ажлын байр бий болж ХЭДСангаас 91060.6 мянган төгрөг зарцууллаа.</p> <p>2010 онд төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, үүний хүрээнд ажлын байр шинээр бий болгох, мэргэжилтэй ажилчид бэлтгэхэд анхаарлаа хандуулж, орон нутагт хэрэгжиж байгаа жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүрээнд 119 хүнийг ажлын байраар ханган, ажил олгогчдын ажлын байрны шаардлагад нийцсэн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх сургалтын 5 хөтөлбөрийг нийгмийн түншүүд болон ажил олгогчидтой хамтран боловсруулж иргэд, аж ахуйн нэгжээс нэн шаардлагатай ажил мэргэжлийн судалгаа авч, сургалтуудыг явуулав. Эрчимжсэн мал аж ахуйн мэргэжлээр шинээр элсэлт авч 211 мэргэжилтэй ажилтан бэлтгэж 100 хувь ажлын</p>		
--	--	--	--	--

		байраар хангагдлаа. “Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан орон нутагт бэлтгэх сургалтанд 6 мэргэжлээр 120 хүнийг элсүүлэн авлаа. 2010 онд 14 сумын 30 бүлийн төслийг шалгаруулж 30,0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэн үйл ажиллагааг нь дэмжиж, бүлийн гишүүдийг чадавхижуулан тухай бүр мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.		
6	Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга, хариуцлагыг өндөржүүлж ажиллана	Аймгийн “Иргэдийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2010 онд “Эрх зүйн мэдээллийн танхим”-ыг нийт 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 суманд байгуулж, ХЗДХЯам, НҮБХХ-ийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр Хархорин суманд “Эрх зүйн туслалцааны төв”-ийг байгуулан ажиллуулав. Аймгийн “Эрх зүйн туслалцааны төв” нь хууль зүйн туслалцаа хүссэн нийт 360 хүнд зөвлөгөө өгч, хууль эрх зүйн 25 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 900 гаруй иргэн хамруулав. Мөн эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй 46 иргэний эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцлоо. “Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай ажиллах журам”-ыг аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс батлан хэрэгжүүлснээр хуулийн байгууллагуудын мэдээлэл сурталчилгааны давхардал арилж, иргэдэд хүртээмжтэй сэдвээр тогтмол хугацаанд эрх зүйн сургалт сурталчилгаа явуулж хэвшээд байна. “Гэмт хэрэг хэв журмын зөрчилгүй сум, баг, байгууллага, иргэн” шалгаруулах болзлыг гарган ажиллав. Аймгийн ГХУССАЗЗ-өөс гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулан, “Аймгийн Хүүхдийн хууль зүйн хорооны хорооны дүрэм”-ийг батлаж, гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, ялтайд тооцогдогч, гэрч, хохирогч гэх зэрэг хүүхдийн эрхийн асуудалд тус хорооны ажил чиглэгдэж байна. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор иргэдийн “Нийтийн эргүүл”-ийг өдөр бүр тогтмол ажиллуулж, улмаар Арвайхээр суманд “Цагдаагийн хөдөлгөөнт эргүүл”-ийг ажиллуулж, 2 автомашин, 10 мотоцикльтой болгосноор иргэдийн аюулгүй тайван орчинд амьдрах, гэмт хэрэг зөрчлийг шуурхайн түргэн цаг алдалгүй илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авснаар гэмт хэрэг зөрчил буурахад нөлөөллөө. Хархорин сумын төвийн баг бүрийг хэв журмын албаны офицер, цагдаа нарт хариуцуулан мал болон орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчлан сэргийлэх чиглэлээр “Морин жим” жуулчны отготой хамтран цагдаагийн морин эргүүлийг гарган ажиллуулж байгаа нь үр дүнгээ өгч байна. “Архигүй орчин- Бидний гэрэлт ирээдүй” уриан дор шилжин явах туг, дэвтрийг шинээр бий болгон аж ахуйн нэгж, байгууллагуудаар аялуулж, аяны хүрээнд 2010 оны 12 дугаар сард ГХЗУСАЗЗөвлөлөөс “Архидан согтуурахтай тэмцэх хамтын	100	5.0

		<p>ажиллагааг сайжруулж” сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулав. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил, архи дан согтуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд үйлчлэх, хууль сурталчлах, санал хүсэлт, гомдлыг хүлээн авах “Цагдаа-олон нийттэй харилцах төв” байгуулан ажиллав.</p> <p>2010 оны 05 дугаар сарын 15-аас 25-ны өдрийг хүртэл хугацаанд аймгийн хууль хяналтын байгуулагуудтай хамтран бүх сумдын архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд шалгалт хийж, дүнг хүргүүллээ. Энэхүү шалгалтаар аймгийн 19 сумын 67 аж ахуйн нэгж аж ахуйн нэгж, 239 иргэн хамрагдан оролцлоо. Шалгалтанд хамрагдсан худалдаа, үйлчилгээний газруудын 85 хувьд даавуу болон цаасан уутыг хэрэглэж хэвшиж байгаа нь сайн байгаа бөгөөд худалдаа, үйлчилгээний газруудад архины сурталчилгаа, цагийн хуваарьтай холбоотой зөрчил урьд оноос багассан байна. Аймагт архи дан согтуурах явдалтай тэмцэх 2.0 сая төгрөгийн сан байгуулаа.</p>		
7	<p>Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцааг авч ажиллана</p>	<p>2010 онд УИХ-ын 3 тогтоол, Ерөнхийлөгчийн 2 зарлиг, Засгийн газрын 90 тогтоол, шийдвэрийн 144 заалтыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулсны үр дүнд тогтоол, шийдвэрийг 94.3 хувьтай хэрэгжүүлэн ажиллав.</p> <p>“Сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 03 дугаар албан даалгаврын биелэлтийг сар бүрийн 10-ны дотор нэгтгэж ЗГХЭГ-т хүргүүлээ.</p> <p>“Хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн ИТХурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцон ажиллах чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын тухай Нарийнтээл сумын Засаг дарга О.Түмэнжаргалын сонсголыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгч ажилласнаар тус сумын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцох, хяналт тавих, мэдээлэх тайлагнах ажил журмын дагуу явагдаж үр дүнд хүрлээ.</p> <p>Аймгийн Засаг даргын 2010 оны 408 захирамжаар “Хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, үр дүн, гүйцэтгэлийг мэдээлэх журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2010 оны 137 дугаар тогтоолын биелэлт болон 2010-2011 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар аймгийн Засаг дарга нь Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хийж, аймаг, орон нутагт тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулан, Засгийн газраас шийдвэр гаргуулан ажиллав.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд орон нутагт ажиллах үеэр аймаг, сумдын удирдлага, иргэдээс олон жил шийдвэрлэгдэхгүй байсан Богд сумыг эрчим хүчинд холбох санал хүсэлтийг тавьж, асуудлыг шийдвэрлүүлэхээр болж, 1,5 тэрбум төгрөгийн төсөвтэй агаарын шугам, дэд станцын ажлын эхний санхүүжилт 750 сая төгрөг 2011 оны төсөвт тусгагдлаа.</p>	95	4.7

8	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авлига, хээл хахуульд холбогдсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаас чөлөөлөгдөх асуудал улс төрийн намын хаацайлыг эрэлхийлэх шалтгаан болохгүй	Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга, Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн өмчит хувьцаат компанийн захирал, эрхлэгч нийт 64 хүнтэй аймгийн Засаг дарга ажил хэргийн уулзалт хийж, төрийн албан хаагчдын болон төсвийн сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй хүргэж, нээлттэй ил тод ажиллах, албан хаагчидтай хариуцлага тооцож ажиллах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг шалгав. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг төрийн албан хаагчдад танилцуулан, төрийн байгууллагуудад хүргүүлж, байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан журамлаж, үр дүнгийн гэрээнд тусган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2009 оны “Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг тооцон аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 3 удаа хэлэлцүүлж, ажлын хариуцлага алдсан 32 төрийн албан хаагч, 4 ерөнхий менежерт сануулах болон цалин, албан тушаал бууруулах, 3 төрийн албан хаагчийг төрийн албанаас халах зэрэг сахилгын шийтгэл ногдуулав. “Төрийн албан хаагчдийн манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тухай Богд сумын Засаг дарга А.Адъяатогтохын сонсголыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, тэмдэглэлээр үүрэг өглөө. Аймгийн Засаг дарга нь төсвийг хуулийн хүрээнд зарцуулж өр, авлага гаргалгүй, төрийн байгууллагуудын төсвийн сахилгыг сайжруулан ажиллаж, авлига хээл хахуульд холбогдолгүй “Батламж”-аар хүлээсэн үүргээ чандлан биелүүлж ирлээ.	100	5.0
9	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил тутам Засгийн газарт тайлагнана	Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан батламжийн биелэлтийг 28 шалгуур үзүүлэлтээр тооцон дүгнэхэд батламжийн биелэлтийг дундаж үнэлгээ 90.8 хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэгдлээ. Батламжийн биелэлтийг жил бүр Засгийн газарт тайлагнан ажиллаж байна.	90	4.5
10	Батламж нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.	Энэхүү батламж хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	100	5.0
<b>БИЕЛЭЛТИЙН ХУВЬ, ОНОО</b>			<b>97.5</b>	<b>4.9</b>

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**

**ЗАСАГ ДАРГА**

**Д.ТОГТОХСҮРЭН**